

БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түргэн сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2025 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: BatAmgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн Баян жанжин хишиг аудит
ХХК-ийн аудитор: А.Дугармаа
Утас: 99542180, Цахим хаяг: baynjanjinxishig@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Дүгнэлтийн үндэслэл	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026-01-30 № УВН-2026/164/НА-СТН-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түргэн сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Түргэн сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050305

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>63,475,450.00</u>	<u>67,926,266.43</u>
33	АВЛАГА	00.00	54,016.43
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	2,016.43
335	Бусад авлага	00.00	52,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	52,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	63,475,450.00	67,872,250.00
354	Хангамжийн материал	63,475,450.00	67,872,250.00
35410	Бичиг хэргийн материал	145,000.00	83,300.00
35420	Аж ахуйн материал	63,330,450.00	67,788,950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,785,616,966.64</u>	<u>1,874,379,670.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,785,616,966.64	1,874,379,670.03
392	Биет хөрөнгө	1,745,600,966.64	1,838,611,670.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,740,016,524.00	1,740,016,524.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-88,557,810.12	-118,002,708.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,340,998.00	175,104,498.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,163,355.78	-45,177,613.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,214,831.00	64,014,831.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,660,311.46	-31,828,952.05
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	31,437,750.00	31,437,750.00
39217	Ном	22,972,341.00	23,047,341.00
393	Биет бус хөрөнгө	40,016,000.00	35,768,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,016,000.00	35,768,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,849,092,416.64</u>	<u>1,942,305,936.46</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>9,114,635.19</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	9,114,635.19
413	Өглөг	00.00	9,114,635.19
4136	Бусад өглөг	00.00	9,114,635.19
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	8,604,635.19
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	510,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,849,092,416.64</u>	<u>1,933,191,301.27</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,849,092,416.64	1,933,191,301.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	74,361,582.00	70,113,582.00
51101	Өмч: - төрийн	74,361,582.00	70,113,582.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,748,835,678.64	1,837,182,563.27
51210	Өмнөх үеийн үр дүн	1,748,835,678.64	1,748,835,678.64

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	88,346,884.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,895,156.00	25,895,156.00
6	ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,849,092,416.64	1,942,305,936.46

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	359,443,619.07	414,569,904.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,906,450.00	144,536,504.74
120	Нийтлэг татварын бус орлого	71,906,450.00	144,536,504.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,636,450.00	10,539,004.74
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,648,450.00	4,578,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,988,000.00	5,961,004.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	287,537,169.07	270,033,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,441,700.00	60,512,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,441,700.00	60,512,200.00
1330	Төсвийн захирагчдаас	212,095,469.07	209,521,200.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	212,095,469.07	209,521,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	324,134,116.64	326,223,020.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324,134,116.64	326,223,020.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,472,683.80	317,812,239.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	157,803,946.89	168,405,048.03
210101	Үндсэн цалин	106,797,497.93	108,136,402.21
210102	Нэмэгдэл	39,214,772.96	48,550,484.82
210104	Урамшуулал	11,791,676.00	11,718,161.00
2102	Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,718,607.37	20,538,354.87
210201	Тэтгэврийн даатгал	13,325,713.33	14,245,130.23
210202	Тэтгэмжийн даатгал	1,498,064.42	1,594,582.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	751,772.66	797,291.36
210204	Ажилгүйдлийн даатгал	597,090.86	749,427.46
210205	Эрүүл мэндийн даатгал	2,545,966.10	3,151,923.53
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,536,715.80	73,612,339.93
210301	Гэрэл, цахилгаан	2,093,030.25	1,968,653.28
210302	Түлш, халаалт	71,443,685.55	71,443,686.65
210303	Цэвэр, бохир ус	00.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,826,600.00	1,729,200.00
210401	Бичиг хэрэг	640,100.00	471,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,767,000.00	738,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	386,100.00	343,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.00	00.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	773,400.00	177,000.00
2105	Нормативт зардал	500,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	770,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	770,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,079,000.00	4,420,000.00
210702	Дотоод албан томилолт	4,079,000.00	4,420,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,045,390.00	972,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,602,690.00	822,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,442,700.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,962,423.74	47,364,796.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,737,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,962,423.74	45,627,796.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,661,432.84	8,410,780.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,820,000.00	1,072,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,040,000.00	1,072,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	82,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	82,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,841,432.84	7,256,580.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	7,256,580.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	35,309,502.43	88,346,884.63
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	35,309,502.43	88,346,884.63

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	292,185,619.07	274,611,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,648,450.00	4,578,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,648,450.00	4,578,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,648,450.00	4,578,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,648,450.00	4,578,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	287,537,169.07	270,033,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	75,441,700.00	60,512,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	75,441,700.00	60,512,200.00

1330	Төсвийн захирагчдаас	212,095,469.07	209,521,200.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	212,095,469.07	209,521,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	286,588,192.90	265,677,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	286,588,192.90	265,677,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	268,926,760.06	257,266,619.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	157,793,946.18	168,411,854.17
210101	Үндсэн цалин	106,797,497.93	108,143,208.35
210102	Нэмэгдэл	39,204,772.25	48,550,484.82
210104	Урамшуулал	11,791,676.00	11,718,161.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,728,608.08	20,533,565.16
210201	Тэтгэврийн даатгал	13,335,714.04	14,238,323.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,498,064.42	1,594,582.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	751,772.66	797,291.36
210204	Ажилгүйдлийн даатгал	597,090.86	749,427.46
210205	Эрүүл мэндийн даатгал	2,545,966.10	3,153,939.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,536,715.80	59,612,200.00
210301	Гэрэл, цахилгаан	2,093,030.25	1,968,653.28
210302	Түлш, халаалт	71,443,685.55	57,443,546.72
210303	Цэвэр, бохир ус	00.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,077,100.00	1,735,000.00
210401	Бичиг хэрэг	712,200.00	409,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,542,900.00	738,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	653,100.00	343,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	908,900.00	244,500.00
2105	Нормативт зардал	500,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	818,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	818,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,079,000.00	3,344,500.00
210702	Дотоод албан томилолт	4,079,000.00	3,344,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,211,390.00	1,074,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,708,690.00	924,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	150,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,502,700.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,737,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,737,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,661,432.84	8,410,780.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,820,000.00	1,072,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,040,000.00	1,072,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	780,000.00	00.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	82,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	82,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,841,432.84	7,256,580.67
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	7,256,580.67
213504	Хөрөнгийн	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,597,426.17	8,934,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,654,900.00	8,934,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,654,900.00	8,934,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,654,900.00	8,934,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,654,900.00	8,934,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,654,900.00	-8,934,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-5,057,473.83	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,057,473.83	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

						/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	66,333,582.00	108,178,261.00	-115,084,231.36	00.00	59,427,611.64
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	66,333,582.00	108,178,261.00	-115,084,231.36	00.00	59,427,611.64
C07	Тайлант үсийн үр дүн	00.00	00.00	10,859,984.78	00.00	10,859,984.78
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,361,582.00	25,895,156.00	1,748,835,678.64	00.00	1,849,092,416.64
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	74,361,582.00	25,895,156.00	1,748,835,678.64	00.00	1,849,092,416.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	74,361,582.00	25,895,156.00	1,748,835,678.64	00.00	1,849,092,416.64
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-4,248,000.00	00.00	00.00	00.00	-4,248,000.00

D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	88,346,884.63	00.00	88,346,884.63
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	70,113,582.00	25,895,156.00	1,837,182,563.27	00.00	1,933,191,301.27

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	213,365,800.00	206,842,619.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	213,365,800.00	206,842,619.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	212,293,600.00	205,770,419.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	169,986,900.00	168,411,854.17
210101	Үндсэн цалин	101,762,200.00	108,143,208.35
210102	Нэмэгдэл	57,350,400.00	48,550,484.82
210104	Урамшуулал	10,874,300.00	11,718,161.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,248,400.00	20,533,565.16
210201	Тэтгэврийн даатгал	14,487,000.00	14,238,323.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,690,300.00	1,594,582.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	845,200.00	797,291.36
210204	Ажилгүйдлийн даатгал	845,200.00	749,427.46
210205	Эрүүл мэндийн даатгал	3,380,700.00	3,153,939.96
2104	Хангамж, бараа материалын зардал	1,810,200.00	1,810,000.00
210401	Бичиг хэрэг	360,000.00	409,300.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	738,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	343,200.00
210404	Ном, хэвлэл	00.00	75,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,200.00	244,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,859,200.00	8,859,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,859,200.00	8,859,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,344,500.00	3,344,500.00
210702	Дотоод албан томилолт	3,344,500.00	3,344,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,900,000.00	1,074,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,750,000.00	924,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	314,440.00	173,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	314,440.00	173,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	107,220.00	107,220.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,072,200.00	1,072,200.00

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,072,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,072,200.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	215,349,200.00	206,842,619.33
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	210,771,200.00	202,264,619.33
131001	Улсын төсвөөс санхүүжих	210,771,200.00	202,264,619.33
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,578,000.00	4,578,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,578,000.00	4,578,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.50	6.50
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3.50	3.50
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00

2.6 АУДИТ ХИЙСЭН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	/төгрөгөөр/	
				Гүйцэтгэл зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,512,200.00	60,430,200.00	82,000.00	99.9%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,512,200.00	60,430,200.00	82,000.00	99.9%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,512,200.00	60,430,200.00	82,000.00	99.9%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,612,200.00	59,612,200.00		100%
210301	Гэрэл цахилгаан	3,163,300.00	1,968,653.28	1,191,646.72	62.2%
210302	Түлш, халаалт	55,900,500.00	57,443,546.72	-1,543,046.72	102.8%
210303	Цэвэр, бохир ус	548,400.00	200,000.00	348,400.00	36.5%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	900,000.00	818,000.00	82,000.00	90.9%
210604	Урсгал засвар	900,000.00	818,000.00	82,000.00	90.9%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	60,512,200.00	60,430,200.00	82,000.00	99.9%
1310	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60,512,200.00	60,430,200.00	82,000.00	99.9%
132001	Орон нутгийн төсвөөс	60,512,200.00	60,430,200.00	82,000.00	99.9%

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6.50	6.50		100%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		100%
620002	Гүйцэтгэх ажилтан	3.50	3.50		100%
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00		100%

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын тухай хуулийг хэрэгжүүлж, үндэсний болон хүн төрөлхтний соёл урлагийг эрхэмлэн, дээдэлж түүхийн үнэт зүйлсээс суралцах өвлөн уламжлах бүтээн туурвих түгээн дэлгэрүүлэх, бүс нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх зорилготой.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Түргэн сумын Соёлын төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд

- Соёлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ хадалдан авах тухай хууль
- Хэмнэлтийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдсөн
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,
- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”

- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн бараа ажил үйлчилгээ худалда авах тухай хуульд 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр тус тус шинэчлэн тогтоосон байна.
- ✓

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түргэн сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түргэн сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 93,211.5 мянган төгрөгөөр буюу 5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		54.0	54.0
Бараа материал	63,475.4	67,872.2	4,396.8
Үндсэн хөрөнгө	1,785,616.9	1,874,379.7	88,762.8
Нийт хөрөнгө	1,849,092.4	1,942,305.9	93,213.5
Өр төлбөр	0,00	9,114.6	9,114.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,849,092.4	1,933,191.3	84,098.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,849,092.4	1,942,305.9	93,213.5

Авлага дансны үлдэгдэл 54.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ажиллагсадтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 67,872.2 мянган төгрөг болж 4,396.8 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой. Бараа материал дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,942,305.9 мянган төгрөг болж, 88,762.8 мянган төгрөгөөр өссөн нь тоног төхөөрөмж 113,404.5 мянга, тавилга хэрэгсэл 17,800.0 мянган төгрөгөөр нэмэгдэж тайлант оны элэгдлийн зардал өссөнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,933,191.3 мянган төгрөг болж 84,098.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 9,114.6 мянган төгрөгөөр өссөн нь халаалтын зардлын санхүүжилт дутуу мөн ажилтанд олгох томилолтын зардлын өр үүссэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 432,695.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 172,731.1 мянган төгрөгөөр санхүүжилт дутуу ирсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 215,349.2 мянга, орон нутгийн төсвөөс 60,512.2 мянга, нийт 275,861.4 төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 202,264.6 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 4,578.0 мянга, нийт 206,842.6 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 206,842.6 мянган төгрөгийг зарцуулжээ.

Орон нутгийн төсвөөс гүйцэтгэлээр 60,430.2 мянган төгрөгийн төсөв бүрдүүлж, түлш халаалтын зардалд 57,443.5 мянга, гэрэл цахилгааны зардалд 1,968.6 мянга, цэвэр усны зардалд 200.1 урсгал засварын зардалд 818.0 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 82.0 мянган төгрөг төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 267,272.8 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,575.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 714.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 1,407.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа/80101/	199,873.3	196,865.2	3,008.0	98%
2	Байр ашиглалтай холбоотой зардал /80111/	60,512.2	60,430.2	82.0	99%

3	Урлаг уран бүтээл /80214/	3,750.0	924.5	2,825.5	24.3%
4	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт /81855/	7,148.0	6,458.4	689.6	97%
5	Нэмэлт дээд шатны/83603/	2,594.5	2,594.5	0.00	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Түргэн сумын Соёлын төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Түргэн сумын Соёлын төвийн тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Түргэн сумын Соёлын төвийн 2025 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй бөгөөд 2,289.8 мянган төгрөгийн бараа материал 8,934.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Түргэн сумын Соёлын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян жанжин хишиг аудит ХХК-ийн аудитор А.Дугармаа гүйцэтгэж, хяналтыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Ариунсайхан, аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Түргэн сумын Соёлын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян жанжин хишиг аудит ХХК-д 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 248,692.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,486.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 326,223.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 3,262.2 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 2,609.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Түргэн сумын Соёлын төвийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 164, хугацаа хоцроож 5 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Түргэн сумын Соёлын төв 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 440.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 19,389.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн биелэлтийг бүрэн хангаж 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар албан бичгээр байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Түргэн сумын Соёлын төвийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 13,602.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Газар эзэмших эрхийг данс бүртгэлээс хасахдаа Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ дансыг 4,248.0 мянган төгрөгөөр бууруулж тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг зөрчсөн тул залрууллаа.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулж тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг зөрчсөн тул залрууллаа.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: БАЯН ЖАНЖИН ХИШИГ АУДИТ
ХХК-ийн ЗАХИРАЛ, АУДИТОР

/А.ДУГАРМАА/

2026 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр

